



НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/578 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан биеийн давхцахгүй өгөгдөл ашиглан цаг бүртгэлийг шинэчлэх хуулийн хэрэгжилтийг мөрдөж ажилласугай.

2. Дээрхи хуулийн хэрэгжилтийн хүрээнд гар хурууны хээг уншигч төхөөрөмж болон өгөгдлийг агуулж буй файл, баазыг устгах, хүчингүй болгох, хуульд нийцүүлэн өөрчлөх ажлыг гүйцэтгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.


3. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг судалж танилцах, хуулийг хэрэгжилтийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор ханган гар хурууны хээг устгасан талаар тайлан, мэдээ холбогдох баримтыг танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Л.Мөсчихэр)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтийг бүрэн хангуулж, хяналт тавин ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (Ч.Шинэчимэг)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Л.ДЭЛГЭР



Нийтлэг үйлчилгээний газрын даргын
2022 оны 04 дүгээр сарын 08-ны
өдрийн 07 дугаар тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ:

Л.Мөсчихэр
Инженерийн байгууламжийн ашиглалт,
үйлчилгээний албаны дарга

ГИШҮҮД:

Ю.Хүслэн
Хууль эрх зүй, тогтоол шийдвэрийн
хэрэгжилт хариуцсан ажилтан

Н.Булганчимэг
Хүний нөөц, дотоод ажил хариуцсан
ажилтан

Б.Батсүрэн
Ерөнхий инженер

Б.Билгүүтэй
Мэдээлэл холбоо, дохиоллын инженер